



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А - 162

Улаанбаатар хот

Өр, орлогын харьцааны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, 22¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцааг 55 хувиас хэтрүүлэхгүй байхыг бүх банканд үүрэг болгосугай.

2.Энэ тушаалыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс мөрдүүлэхээр тогтоосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А-83 дугаар тушаалын 1 дэх заалтыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1524011210